



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар A/388

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг нягтлан шалгах, мэргэжлийн байгууллагыг ажиллуулах, зөвлөн туслах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Нямжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Бат-Оргил (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн хяналт, шинжилгээ-үнэлгээ, хууль сахиулах бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн)

Б.Бямбажав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн агентлаг, сумдын бодлого шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн)

Ц.Баасанжаргал (Аймгийн Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Л.Нямгэрэл (Эрүүл мэндийн газрын Хяналт, шалгалтын хэлтсийн эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын байцаагч)

Л.Батжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Б.Отгонгэрэл (Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийн хурлыг хуралдуулан, удирдамж боловсруулан батлуулж, хэрэгжилт, үр дүнг 2024 оны 07 дугаар сарын 31-ний дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Нямжав)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.



ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712011155

Захирамж 2024